

“ABU ROBOCON 2019 Ulaanbaatar” СОРИЛ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Удиртгал

Ази Номхон далайн орнуудын “ABU ROBOCON” роботын тэмцээнийг Монгол улсад анх удаа зохион байгуулахаар болсон. Иймээс энэ олон улсын уралдаанд оролцох монгол залуусын робот бүтээх ажлыг илүү чадваржуулах, бие биенээсээ харилцан туршлага солилцох боломжийг олгох зорилгоор энэхүү сорилийг явуулж байна. Уг сорилийг “ABU ROBOCON 2019 ULAANBAATAR” олон улсын роботын тэмцээний дүрмийн дагуу хялбаршуулсан хэлбэрээр хийнэ.

Сорил тэмцээнд оролцсон багууд “ABU ROBOCON 2019 ULAANBAATAR” үндэсний аварга шалгаруулах роботын тэмцээний дараагийн шатны тэмцээнд оролцох эрхээ авна.

Тэмцээний дүрэм

Сорил тэмцээн үндсэн хоёр хэсэгтэй.

1. Гар удирдлагат (MR1) роботын шагай шидэх тэмцээн.
2. Автомат (MR2) роботын уралдаан.

Хэсэг тус бүрээс шилдэг хоёр багийг шалгаруулж урамшуулна. Мөн эдгээр багууд 2-р сард болох үндэсний аварга шалгаруулах тэмцээний **1-р шатанд бүс толгойлон оролцох эрхтэй болно.**

Тоглолтын дүрэм:

Роботонд тавигдах шаардлага, тэмцээний оноо зэрэг нь “ABU ROBOCON 2019 Улаанбаатар” роботын тэмцээний дүрмийн дагуу баримтлан явуулна.

Тэмцээний 1-р хэсэг:

MR1 нь ой ба гүүрийг давж, шугамын ард байрлуулсан гурван шагайг шидэж, хамгийн өндөр оноо цуглуулсан баг ялагч болно.

MR1-ын хувьд ялагчийг тодруулахдаа:

1. Өндөр оноо авсан
2. Ой, гүүрийг богино хугацаанд давсан
3. Хол зам туулсан
4. Шүүгчийн шийдвэр

Тэмцээний 2-р хэсэг:

MR2 нь говийн бүсээр явж шугамыг бүрэн давснаар ялагч болно.

MR2-ын хувьд ялагчийг тодруулахдаа

1. Барианд түрүүлж орсон робот
2. Хол зам туулсан
3. Шүүгчийн шийдвэр

Тоглолтын хугацаа:

Хэсэг тус бүрийн бэлтгэх хугацаа 30секунд, тоглолтын үргэлжлэх хугацаа нэг минут байна.

Тоглолтын талбай

Хавсралтад үзүүлэв. Жич: Талбайн хэмжээг удахгүй тодорхойлно.

Зохион байгуулах хороо

Харилцах утас 99056650, 88056650

Email хаяг ariun_mng@yahoo.com, baigalaa_79@yahoo.com

2018 оны 10-р сар

Хавсралт
“ABU ROBOCON 2019 Ulaanbaatar”
Сорил тэмцээний удирдамж

